



# СОЁМБОМ ЭДЭЭ

МОНГОЛ УЛСЫНХАА ТӨЛӨӨ ЗҮТГЭЭ!

№13 /227/

ӨДӨР ТУТМЫН ЦАХИМ СОНИН

2022.01.17

Цаг үе, үйл явдал

## ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ УДИРДАХ БҮРЭЛДЭХҮҮНИЙ СТРАТЕГИЙН ЦУГЛАРАЛТ ЭХЭЛЛЭЭ



Зэвсэгт хүчний удирдах бүрэлдэхүүний стратегийн цуглалт өнөөдрөөс эхэллээ. Энэхүү цуглалт цар тахлын халдвараас урьдчилан сэргийлэх хүрээнд дөрвөн танхимд цахимаар болон шууд зохион байгуулагдаж байгаа бөгөөд үүний нэг нь Хуурай замын цэргийн командлал, түүний харьяа нэгтгэл, ангиудын удирдлага Төв аймгийн Зуунмод сумаас оролцож байгаа юм.

Цуглалтын эхэнд ЗХЖШ-ын орлогч дарга, бригадын генерал Ч.Цогтжаргал явагдах сургалтууд, түүний онцлогийн талаар дурдаж, энэ үед цар тахлын халдвараас сэргийлж, халдвар хамгааллын дэглэмээ сайтар баримтлахыг санууллаа. ЗХЖШ-ын дарга, дэслэгч генерал Д.Ганзориг цуглалтыг нээж, нийт удирдах бүрэлдэхүүнд хандаж үг хэллээ.




## ЭНЭТХЭГ-НОМХОН ДАЛАЙН БҮС НУТГИЙН ОРНУУДЫН ЖАНЖИН ШТАБЫН ДАРГА НАРЫН ЦАХИМ ХУРАЛ БОЛОВ

ЗХЖШ-ын дарга дэслэгч генерал Д.Ганзориг өнгөрсөн долоо хоногт Энэтхэг-Номхон далайн бүс нутгийн орнуудын Жанжин штабын дарга нарын цахим хуралд оролцлоо. Уг хурлыг Энэтхэг-Номхон далай дахь АНУ-ын цэргийн командлагч адмирал Акулино удирдан 2022 онд Бүс нутгийн орнуудын дэвшүүлж буй стратегийн үндсэн чиглэлийн тухай санал бодлоо солилцлоо.

ЗХЖШ-ын дарга, дэслэгч генерал Д.Ганзориг уг хуралд оролцох үеэрээ Монгол Улсын Зэвсэгт хүчин 2022 онд энхийг

сахиулах ажиллагаанд оролцож эхэлсний 20 жилийн ойг тэмдэглэнэ, мөн НҮБ-ын энхийг сахиулах ажиллагаанд шинээр цэргийн баг оролцуулах, дотоодын бүтээн байгуулалт төсөл хөтөлбөрт оролцох, цар тахлаас урьдчилан сэргийлэх, бууруулах чиглэлээр төр засагт дэмжлэг үзүүлэх зэрэг зорилтуудыг дэвшүүлж буй талаар дурдлаа. Сонирхуулахад, Энэтхэг-Номхон далайн бүс нутгийн орнуудын Жанжин штабын дарга нар ирэх 7 дугаар сард Австралид хуралдах аж.



## КОМИССЫН БҮРЭЛДЭХҮҮН ХУРАЛДАВ



Батлан хамгаалахын сайдын 2019 оны А/103 дугаар тушаалаар батлагдсан Батлан хамгаалах салбарт шинээр баригдсан болон их засвар хийгдсэн барилга, байгууламжийг хүлээн авч, ашиглалтад оруулах ажлын комиссын бүрэлдэхүүнийг Батлан хамгаалахын ерөнхий хянан шалгагч бригадын генерал Ж.Болдбаатар 2022 оны 01 дүгээр сар 14-ний өдөр хүлээн авч уулзлаа.

Тус уулзалтаар улсын төсвийн болон Зэвсэгт хүчний хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар батлан

хамгаалах салбарт баригдаж буй барилга, засварын ажлын явц, үр дүнийн талаар Батлан хамгаалах яамны Стратегийн бодлого, төлөвлөлтийн газрын хэлтсийн дарга, ажлын хэсгийн комиссын дарга, хурандаа Д.Дашзэвэг танилцуулж, Батлан хамгаалахын ерөнхий хянан шалгагч бригадын генерал Ж.Болдбаатар комиссын бүрэлдэхүүнд ажлын хариуцлага, гүйцэтгэлийг эрчимжүүлэн ажиллах талаар тодорхой үүрэг, чиглэлээр ханган ажиллалаа.



## МОНГОЛ УЛС ДАХЬ КОРОНАВИРУСИЙН МЭДЭЭ

ВАКЦИНЖУУЛАЛТ I ТУН	ВАКЦИНЖУУЛАЛТ II ТУН	ДАРХЛАА СЭРГЭЭХ ТУН
2,267,969 /69.7%/	2,168,125 /66.6%/	968,478 30,0%

## ЦЭРГИЙН ТӨВ ЭМНЭЛЭГ

НИЙТ БАТЛАГДСАН	ХЭВТЭН ЭМЧЛҮҮЛЖ БУЙ	ЭДГЭРСЭН
7562 +112	198	7248

## КОРОНАВИРУС ДЭЛХИЙ ДАХИНД

Тохиолдол	Нийт: 328,826,023
Эдгэрсэн	Нийт: 267,714,615
Нас барсан	Нийт: 5,557,754

## Түүхэнд энэ өдөр

1938 он ЦЯЯ-ны сайд, Бүх цэргийн жанжны "Уурын машины эвдрэл гэмтлийг тодорхойлон магадлах цаг үргэлжийн комиссыг томилох тухай" тушаал гарчээ.  
1956 он. "Биеийн тамир спортын ажлыг сайжруулах тухай" сайдын тушаал гарч, анги салбарт биеийн тамирын хороо секц байгуулан ажиллуулах, ардын хувьсгалын 35 жилийн ой угтаж 1000 хүний гимнастикийн үзүүлэх тоглолт хийхээр шийдвэрлэжээ.

## ЦАГ АГААР

УЛААНБААТАР

ӨДӨР	ШӨНӨ
-9	-25


ӨМНӨД СУДАН

ӨДӨР	ШӨНӨ
37	22

## ВАЛҮТЫН ХАНШ

ВАЛҮТ	АВАХ	ЗАРАХ
USD	2,852.00	2,855.0
EUR	3,255.0	3,265.0
CNY	448.00	449.20
RUB	38.10	39.40
JPY	24.85	25.00
KRW	2.39	2.40

## ЗУРХАЙ



2022.01.17 ДАВАА ГАРАГ /БИЛГИЙН ТООЛЛЫН 15/

ӨВЛИЙН АДАГ ЦАГААГЧИН ҮХЭР САРЫН ДӨРВӨН НОГООН МЭНГЭТЭЙ ЦАГААН МОРЬ ӨДӨР

Үс засуулбал:

Өлзийтэй сайн

НАРАН УРГАХ, ШИНГЭХ:

08.36-17.29

Барилдлага:

Үл зохилдох

Шүтээн барилдлага:

Төрөн түгэхүй

Суудал: Мод

Энэ өдөр бар, нохой жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн. Эл өдөр архи уух, тамхи татах, сэтгэл муутантай нөхөрлөх зэргийг цээрлэх хэрэгтэй ба лусыг тахиж, тангараг тавих, гэр, байшингийн суурь тавихад сайн. Гэр бүрэх, хэрүүл тэмцэл хийх, сэтгэлд сөвтэй газар очиход муу. Өдрийн сайн цаг нь хулгана, үхэр, туулай, морь, бич, тахиа болой. Хол газар яваар одогсод хойш мөрөө гаргавал зохистой. Үс шинээр үргээлгэх буюу засуулбал өлзийтэй сайн.

ДОРНЫН ЗУРХАЙ: Үс шинээр засуулбал ӨЛЗИЙТЭЙ сайн



Цахим шууданд

# ЦЭРЭГЖЛИЙН СПОРТЫН ӨВЛИЙН 2 ТӨРӨЛТ, ЦСЦ-ЫН ӨВЛИЙН ОЛОН ТӨРӨЛТИЙН ТЭМЦЭЭН ӨНДӨРЛӨЛӨӨ



Агаарын цэргийн командлалын нэрэмжит Зэвсэгт хүчний аварга шалгаруулах Цэрэгжлийн спортын өвлийн 2 төрөлт, ЦСЦ-ын өвлийн олон төрөлтийн тэмцээн Зэвсэгт хүчний 119 дүгээр ангийн Сургалтын төвд амжилттай явагдаж өндөрлөлөө.

Тэмцээний хаалтын ажиллагаа өнгөрсөн бямба гарагт зохион байгуулагдаж шилдгүүдийн шагналыг гардуулсан юм. Тус арга хэмжээнд Зэвсэгт хүчний агаарын цэргийн командлагч хошууч генерал О.Энхбаяр, ЗХЖШ-ын Ажиллагааны удирдлагын газрын дарга бригадын генерал С.Дашзэвэг, ЗХЖШ-ын Сургалтын бодлого, зохицуулалтын хэлтсийн дарга хурандаа Ш.Гантулга болон Зэвсэгт хүчний нэгтгэл ангиудын захирагчид

болон албаны бусад хүмүүс оролцов.

Зэвсэгт хүчний 2021-2022 оны биеийн тамир, спортын уралдаан тэмцээний нээлт болон зохион байгуулагдсан Цэрэгжлийн спортын өвлийн 2 төрөлт болон цэрэгжлийн спортын олон төрлийн тэмцээнүүд цэргийн алба хаагчдын өвлийн сургалт бэлтгэл, байлдааны бэлтгэлийн үндсэн суурь болж өгөхөөс гадна эр зориг, тэсвэр тэвчээрийн илэрхийлэл, цэргийн алба хаагчдаа бэлтгэх, сургах, дадлагажуулах нэг хэлбэр бөгөөд энэ удаагийн тэмцээн ийнхүү долоо хоног үргэлжилж, шилдгүүдээ тодрууллаа.

Зэвсэгт хүчний 2022 оны аварга шалгаруулах "Өвлийн 2 төрөлт"-ийн биатлонд хувийн дүнгээр 1 дүгээр байрт ахлагч О.Гантулга

/337/, 2 дугаар байрт дэслэгч У.Батжаргал /015/, 3 байрт ахлагч Ө.Отгонбаяр /350/ тус тус шалгарлаа. Биатлоны багийн дүнгээр 1 дүгээр байрт ахмад Б.Цээноров, ахлагч Ө.Отгонбаяр /350/, 2 дугаар байрт ахлагч Б.Мөнх-Эрдэнэ, Ц.Ганзориг /084/, 3 дугаар байрт ахлагч О.Гантулга, дэд ахлагч Б.Ганхүү /337/ нар тус тус шалгарсан юм. Мөн Патрулын төрөлд 1 дүгээр байрт ахмад Т.Баатархүү, ахлах ахлагч Б.Батжаргал, ахлагч Б.Мөнх-Эрдэнэ, Ц.Ганзориг /084/, 2 дугаар байрт ахмад Б.Цээноров, ахлагч Ө.Отгонбаяр, Т.Гантулга, дэд ахлагч Д.Энхтайван /350/, 3 дугаар байрт хошууч Б.Хэнзээ, дэслэгч У.Батжаргал, ахлах ахлагч Р.Ганхуяг, ахлагч Батмөнх /015/ тус тус шалгарав. Ийнхүү цэрэгжлийн спортын өвлийн

2 төрөлтийн тэмцээн өндөрлөж, байгууллагын дүнгээр нэгдүгээр байрыг хурандаа Д.Шинэбаяр захирагчтай Зэвсэгт хүчний 084, 2 дугаар байрыг хурандаа Ж.Сүх-Очир захирагчтай Зэвсэгт хүчний 350, 3 дугаар байрыг дэд хурандаа Б.Олзбаяр захирагчтай Зэвсэгт хүчний 150 дугаар ангиуд эзэллээ.

ЦСЦ-ын өвлийн олон төрөлтийн шилдгүүдээр 18-30 насны эрэгтэй төрөлд 1 дүгээр байрыг ахлагч О.Гантулга /337/, 2 дугаар байрыг ахлагч Ө.Отгонбаяр /350/, 3 дугаар байрыг ахлагч Б.Ойгонзаяа /013/, 3 дугаар байрыг ахлагч С.Нандин-Эрдэнэ /350/ нар эзэлсэн бол 31-35 насны эрэгтэй

төрөлд 1 дүгээр байрт ахлах ахлагч Б.Батжаргал /084/, 2 дугаар байрт ахлах ахлагч Ц.Цогтжаргал /326/, 3 дугаар байрт дэслэгч У.Батжаргал /015/, 36-40 насны эрэгтэй төрөлд 1 дүгээр байрыг ахмад Т.Баатархүү /084/, 2 дугаар байрыг ахлах ахлагч С.Эрдэнэбилэг /326/, 3 дугаар байрыг хошууч Б.Хэнзээ /015/, эмэгтэй төрөлд 1 дүгээр байрыг ахлах ахлагч Д.Сүрэнхорлоо /013/, 2 дугаар байрыг ахлагч Б.Баярцэцэг /337/, 3 дугаар байрыг ахлагч Б.Бадамцэрэн /330/, 41 наснаас дээш эрэгтэй төрөлд 1 дүгээр байрыг ахлах ахлагч Б.Ганхуяг /015/, 2 дугаар байрыг сургагч ахлагч Ж.Одгэрэл /017/, 3 дугаар байрыг ахлах ахлагч Б.Цацрал /016/, эмэгтэй төрөлд 1 дүгээр байрыг сургагч ахлагч О.Хүрэлцэцэг

/189/, 2 дугаар байрыг сургагч ахлагч Ж.Одгэрэл /017/, 3 дугаар байрыг ахлах ахлагч Б.Цацрал /016/ тус тус шалгарав.

Эрэгтэй багийн дүнгээр 1 дүгээр байранд хурандаа Д.Шинэбаяр захирагчтай Зэвсэгт хүчний 084 дүгээр анги, 2 дугаар байранд хурандаа Ж.Сүх-Очир захирагчтай 350 дугаар анги, 3 дугаар байранд хурандаа Ч.Эрдэнэболд захирагчтай 013 дугаар анги тус тус шалгарсан бол эмэгтэй багийн төрөлд 1 дүгээр байрыг хурандаа Ч.Эрдэнэболд захирагчтай 013 дугаар анги, 2 дугаар байрыг хурандаа Ш.Цэрэнбат захирагчтай 065 дугаар анги, 3 дугаар байрыг хурандаа Н.Бат-Эрдэнэ захирагчтай Зэвсэгт хүчний 330 дугаар ангиуд тус тус эзэллээ.



## АЛБА, САЛБАРАА СУРТАЛЧИЛСААР БАЙНА



### Зэвсэгт хүчний 016 дугаар нэгтгэл

Нэгтгэлийн алба, салбар сурталчлах аяныг өрнүүлж байна. Аяны хүрээнд Авто хуягт, техникийн албанаас байнгын бие бүрэлдэхүүний дунд "Миний автомашин", "Дөрвөн бэрх" зэрэг уралдаан, тэмцээнүүдийг зохион байгуулж явууллаа. "Миний автомашин" тэмцээнд Мотоубудлагын батальон,

Хими, биологоос хамгаалахын алба тэргүүн байруудыг эзэлсэн бол "Дөрвөн бэрх" тэмцээнд нэгдүгээр байрт танкийн батальон, хоёрдугаар байрт ар тал, гуравдугаар байрт артиллерийн дивизионы багууд тус тус шалгарлаа. Алба, салбар сурталчлах шилжин явах тугийг Мотоубудлагын батальонд шилжүүлэн өгсөн юм.

Хошууч Д.ДОЛГОРЖАВ



## ХУГАЦААТ ЦЭРГИЙН АЛБА ХААГЧИД ҮНДЭСНИЙ ХУВЦАС, ГУТЛАА ХИЙЖ СУРЧ БАЙНА

### Зэвсэгт хүчний 340 дүгээр анги

Тус ангийн удирдлагаас хугацаат цэргийн алба хаагчдыг өв соёлоо эрхэмлэгч, Монгол уламжлалаа түгээн дэлгэрүүлэгч, үнэт баялгийг бүтээгч болгох зорилгын үүднээс Монгол үндэсний өв соёлын салшгүй нэг хэсэг болох үндэсний хувцас, цагаан ултай гутал хийх гар урлалын сургалтын төслийг санаачлан, амжилттай хэрэгжүүлээд байна.

Төслийг санаачлагчдын нэг ангийн зочид буудлын эрхлэгч, сургагч багш Ж.Нарансолонго "Хугацаат цэргийн алба хаагчид маань эхний долоо хоногт гутал эсгэх, түрий оёх, хээ гаргах арга техникийг амжилттай суралцсан төдийгүй маш идэвх санаачилгатайгаар хичээнгүйлэн суралцаж

байна. Цаашид гүнзгийрүүлэн илүү ихийг сурч мэдэхийг хүсэж байна" хэмээн хэлсэн юм.

### Ахлах дэслэгч Б.ДОЛГОРСҮРЭН

